

БАТЛАВ  
ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

2021 оны 05 сарын 03 өдөр

## “МАНАЙ ТӨГӨЛ” НОГООН БАЙГУУЛАМЖИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

**Зорилго:** Мандалговь хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амрах, амьдрах орчныг бүрдүүлэх, ногоон байгууламж ургуулах сэтгэхүйг хүн бүрт суулгах, зам дагуу тарих мод, сөөгийг өөрийн гараар тарьж арчилж ургуулахад уралдааны зорилго оршино.

### Нэг. Хамрах хүрээ, хугацаа

1.1 Сайнцагаан суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд оролцоно.

1.2 Уралдаан 2021 оны 05 дугаар сараас 2023 оны 10 дугаар сар хүртэл

### Хоёр. Тавигдах шаардлага

2.1 Өөрийн төгөлдөө нэр өгч самбар байршуулах.

2.2 Мод тарихаас өмнөх болон ажлын явц, тарьсны дараах үеийн ажлын явцыг харуулсан бодит зураг эсвэл бичлэгийг тусгасан байх

2.3 Норм, хуваарийн дагуу усалсан тэмдэглэл хөтөлдөг байх.

2.4 Усалгаа, арчилгаа хийж буй тайланг улирал бүр ирүүлдэг байх.

2.5 Тухайн хариуцсан талбайд амьдрах чадваргүй болсон модыг авч нөхөн тарилт хийсэн байх.

2.6 Мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол авч, хэрэгжүүлж байх.

### Гурав. Уралдааны шалгаруулалт

3.1 Уралдаанд оролцогчид нь өөрсдийн хийж гүйцэтгэсэн ногоон байгууламжийн ажлуудаа хийхээс өмнө болон хийсний дараах гэсэн зурган хэлбэрээр тайлан болгон ирүүлнэ. Уралдаанд ирүүлсэн материалтай танилцан талбай тус бүрээр амьдралтын хувь тогтоон хүлээн авч, орон нутгийн телевизтэй хамтран уралдаанд оролцогчдыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. Уралдаанд ирүүлэх материалуудыг 2023 оны 10 дугаар сарын 20-25 өдөр хүртэл

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүлээн авч уралдааны дүнг 11 дүгээр сарын 15-ны өдөр танилцуулна.

### **Дөрөв. Шагналын сан**

31-42 мод нүхэнд, 384-492 мод шуудуунд тарьсан  
байгууллага, аж ахуйн нэгж

1 дүгээр байр – өргөмжлөл, 1.500.000

2 дугаар байр – өргөмжлөл, 1.200.000

3 дугаар байр – өргөмжлөл, 800.000

21-30 мод нүхэнд, 264-372 мод шуудуунд тарьсан  
байгууллага, аж ахуйн нэгж

1 дүгээр байр – өргөмжлөл, 1.200.000

2 дугаар байр – өргөмжлөл, 900.000

3 дугаар байр – өргөмжлөл, 700.000

11-20 мод нүхэнд, 144-252 мод шуудуунд тарьсан  
байгууллага, аж ахуйн нэгж

1 дүгээр байр – өргөмжлөл, 1.000.000

2 дугаар байр – өргөмжлөл, 800.000

3 дугаар байр – өргөмжлөл, 500.000

3-10 мод нүхэнд, 48-132 мод шуудуунд тарьсан  
байгууллага, аж ахуйн нэгж

1 дүгээр байр – өргөмжлөл, 500.000

2 дугаар байр – өргөмжлөл, 400.000

3 дугаар байр – өргөмжлөл, 300.000

4 дүгээр байр- өргөмжлөл, 200.000

Жич: Нийт 67 байгууллага, аж ахуйн нэгжүүд зам дагуу мод тарьсан. Тарьсан модны тоогоор 4 ангилсан. Үүнээс 3-10 мод нүхэнд, 48-132 мод шуудуунд тарьсан 40 байгууллага, аж ахуйн нэгж, 11-20 мод нүхэнд, 144-252 мод шуудуунд тарьсан 14 байгууллага, аж ахуйн нэгж, 21-30 мод нүхэнд, 264-372 мод шуудуунд тарьсан 7 байгууллага, аж ахуйн нэгж, 31-42 мод нүхэнд, 384-492 мод шуудуунд тарьсан 6 байгууллага аж ахуйн нэгж байна.

### **Тав. Зохион байгуулагч**

Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Хот тохижуулах газар

## Холбоо барих:

Дэлгэрэнгүй мэдээллийг 70593990, 88582247, 88038798, 88097482 утас, Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар фэйсбүүк группээс авна уу.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР